

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хандивын тайлан ирүүлсэн 51 намын хороо, 1 эвсэл нь Орон нутгийн 2024 оны ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд хандив аваагүй байна.

АУДИТЫН КОД: ХӨА-2024/14-7-ШТА-НА

Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар Утас:88883317
Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр Утас: 99089114
Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Давааням Утас: 88095436
Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn
Аудитор С.Гансүх Утас: 95908400
Цахим хаяг: Gansukhsa@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо Утас: 88688168
Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

**"Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэлд нэгдэн орсон
намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулах" сэдэвт
нийцлийн аудитын тайлан**

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

БҮЛЭГ 1: АЙМАГ, СУМДЫН 2024 ОНЫ ИТХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ НАМ, ЭВСЭЛ НЬ
ХАНДИВЫН ТАЙЛАНГАА АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 37 ДУГААР ЗҮЙЛИЙН 37.7-Д ЗААСАН ХУГАЦААНД,
БАТЛАГДСАН МАЯГТЫН ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛСЭН БАЙНА.

1.1 Аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцохоор 51 намын хороо, 1 эвсэл хуульд заасан хугацаанд хандивын тайлангаа ирүүлсэн байна.....	6
--	---

1.2 Иргэн, хуулийн этгээдээс хандив аваагүй байна.....	6
--	---

ДҮГНЭЛТ.....	6
--------------	---

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/23-1

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитыг байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсэг, 2023 оны А/102 дугаар "Эрх үүрэг шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн удирдамж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан, баталгаажуулах" нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын ажлын баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногт архивын нэгж болгон архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Б.Давааням)-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**"Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэлд нэгдэн орсон
намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулах" сэдэвт
нийцлийн аудитын тайлан**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НА	Нийцлийн аудит
МАН	Монгол ардын нам
ШТА	Шууд тайлагнах аудит
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АНСДИТХ	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөний Аудитор
УИХ	Улсын Их Хурал

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.12, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, МУЕА-ын "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/162 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовын баталсан Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигчдээс ирүүлсэн хандивын тайланд дүгнэлт гаргаж олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцох Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 51 намын хороо, 1 эвслээс ирүүлсэн хандивын тайлан, холбогдох баримтыг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгаж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлтийг боловсрууллаа.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлэн, ахлах аудитор Б.Давааням, аудитор С.Гансүх, Г.Ичинхорлоо нар гүйцэтгэлээ.

Үндсэн мэдээлэл:

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 37 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.8, 12 дугаар зүйлд заасны Хөвсгөл аймгийн орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгууль аймгийн 37 тойрог 41 мандат, сумдын 128 тойрог 504 мандат нийт 165 тойрог 545 мандатад нам, эвслийн нэр дэвшигч болон бие даан нэр дэвшигчид мажоритар буюу олонхын санал авсан нь сонгогдох тогтолцоогоор өрсөлдөнө.

Хандивын тайланг баталгаажуулж дүгнэлт гаргахдаа Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37-55 дугаар зүйлийг үндэслэл болгосон бөгөөд хандив хүлээн авах, тайлагнах үйл ажиллагаанд нарийвчилсан хяналт хэрэгжүүллээ.

БҮЛЭГ 1: Аймаг, сумдын 2024 оны ИТХ-ын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь хандивын тайлангаа аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7-д заасан хугацаанд, батлагдсан маягтын дагуу бэлтгэн ирүүлсэн байна.

1.1 Аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцохоор 51 намын хороо, 1 эвсэл хуульд заасан хугацаанд хандивын тайлангаа ирүүлсэн байна.

Хөвсгөл аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцохоор 51 нам, 1 эвсэл аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн

"Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам эвсэлд нэгдэн орсон намуудад иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянаж баталгаажуулах" сэдэвт нийцлийн аудитын тайлан

25.3.6¹-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс авсан хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7²-д заасан хугацаанд дүгнэлт гаргуулахаар Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн. Үүнд:

- Хөвсгөл аймгийн Монгол ардын намын хороо, 23 сумын монгол ардын намын хороо
- Хөвсгөл аймгийн Ардчилсан намын хороо, 17 сумын ардчилсан намын хороо
- Үндэсний эвсэл /Ногоон намын хороо, Монголын үндэсний ардчилсан намын хороо/
- Хөвсгөл аймгийн Шинэ намын хороо
- Хөвсгөл аймгийн Ард түмний хүч намын хороо
- Хөвсгөл аймгийн Иргэний зориг ногоон намын хороо
- Хөвсгөл аймгийн ХҮН намын хороо
- Хөвсгөл аймгийн Үнэн ба зөв намын хороо
- Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хороо
- Хөвсгөл аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл намын хороо
- Хөвсгөл аймгийн Хөгжлийн хөтөлбөр намын хороо
- Хөвсгөл аймгийн Сайн ардчилсан иргэдийн нэгдэл намын хороо

Дээрх нам, эвслүүд нь хандивын тайлангаа Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дугаар тушаалаар баталсан маягтын дагуу гаргаж ирүүлсэн бөгөөд иргэн, хуулийн этгээдээс хандив аваагүй тул хандив аваагүй талаарх дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.

1.2 Иргэн, хуулийн этгээдээс хандив аваагүй байна.

Хандивын тайланг Аудитын дээд байгууллагуудын Олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.1, 55.1.2, 55.1.3, 55.1.4, 55.1.5, 55.1.6, 55.1.7-д нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулсан болно.

Нам, эвслээс ирүүлсэн хандивын тайланг хянан үзэхэд Улс төрийн намын тухай хууль болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан шаардлагад нийцсэн тул дүгнэлт гаргаж, холбогдох нам, эвслүүдэд албан бичгээр хүргүүлж, хуульд заасан хугацаанд нийтэд мэдээлсэн.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Хөвсгөл аймаг, сумдын ИТХ-ын сонгуульд оролцох нам, эвслүүд нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.3.6³-д заасны дагуу иргэн, хуулийн этгээдээс авсан хандивын тайлангаа мөн хуулийн 37 дугаар зүйлийн 37.7⁴-д заасан хугацаанд дүгнэлт гаргуулахаар Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн бөгөөд хуульд заасан хугацаанд хандив хүлээж аваагүй байна.

_____000_____

¹Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж, баталгаажуулсан тайлан

² Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ

³Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд, ээлжит бус, нөхөн болон дахин сонгуульд тухайн сонгуулийн жилийн өмнөх тайлант жилийн хугацаанд тухайн намд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын төрийн аудитын байгууллагаар хянуулж, баталгаажуулсан тайлан

⁴ Нам, эвсэл нь орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жилийн 06 дугаар сарын 25-ны өдрөөс өмнө энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ